

**“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 04-р сарын 16-ны өдөр

Дугаар:24/01

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын зааланд 2024.04.16-ны өдрийн 16.00 цагт эхлэв.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тоо ллогын комиссын гишүүн Ж.Олонбаяр хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж, хурлын тооллогын комиссын дарга О.Шинэхүүг танилцуулахыг урилаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга О.Шинэхүүгийн танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 127,016.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 8 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 93.9 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д “Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг бүрэн хангаж байна.

Хуралд Э.Тэмүүжин, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэчимэг, Ц.Эрдэнэсүх, Б.Мөнхбат, Г.Алтансүх, С.Пүрэвжав, Б.Сумьяа нарын 8 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн /ХГ84091817/ хурлын материалтай танилцаж, урьдчилан саналаа өгөөд явсан тул хуралд оролцсоноор бүртгэв.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дэг:

1. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулах /20 мин/
2. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсан асуулт, хариулт. /хүн бүр 5 мин/
3. Тоологын комисс санал өгөх журмыг танилцуулж, саналын хуудсаар санал авах
4. Санал хураалтын дүнг шийдвэр бүрээр гаргаж хуралд танилцуулна. /10 мин/
5. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах шийдвэрийг танилцуулах /5 мин/
6. Хурлыг хаах

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө, 2024 оны удирдлагын зардлыг батлах
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг нэмж сонгох

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасан шаардлагын дагуу хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Зууны мэдээ /, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 15 хоногийн давтамжтайгаар 2 удаа тус тус зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2023 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлээ.

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлын тооцоотой та бүхэн компани дээр ирж урьд нь танилцсан, одоо ч та бүхэнд хэвлэж тараасан байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн 1 гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн. Тиймээс 1 гишүүнийг нөхөн сонгохоор гишүүний товч намтрыг тараасан.

Та бүхний санал бодлыг сонсьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Өнгөрсөн оны ажлын үзүүлэлт, ашгийн дүн өндөр гарсан байна. Энэ хөрөнгөөрөө Банк бус санхүүгийн байгууллага байгууллага байгуулах хэрэгтэй санагдана. Энэ талаар ямар бодолтой байгаа вэ компанийн удирдлагын зүгээс? Бизнесийн зорилго тодорхой бол өөрийн бараа бүтээгдэхүүн боловсруулах, бизнес эрхлэх тал дээр боломж өндөр, татвараас чөлөөлөгдөх боломжтой шүү дээ.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Манай компани Lend.mn-ийн 20% хүүтэй бонд авч ажилласан. Хүрд ХК орон сууцны барилга барьж, ББСБ-д хамруулах бодолтой байгаа. Компанийн өнөөгийн байдал, хэтийн төлөвийн талаар 2023 оны 10-р сард ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн. Энэ материалтай та бүхэн танилцсан.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Банк бус санхүүгийн байгууллага нь Санхүүгийн Зохицуулах хороо, Монгол банкны хяналттай байгууллага тул бид итгэдэг. Банк бус санхүүгийн байгууллага байгуулж, өөрийн үйл ажиллагаанд ашигтай байдлаар зохицуулж ажиллах хэрэгтэй. Компанийн газарт орон сууц барих асуудал ямар шатандаа байгаа вэ?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Орон сууц барих төлөвлөгөө хэвээрээ. Тэгэхдээ мөнгө санхүү нь байгаа ч зах зээлийн нөхцөл байдал тогтворгүй байгаагаас харзнаж байна. Арматурын үнэ буурах уу, Шатахуун тасалдалгүй энэ хэвээрээ байх уу гэх мэт асуудал байна.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Хотын төвийн А бүсэд 7 давхраас дээш орон сууц барихыг хориглосон байгаа. Энэ бодлого хэр удаан үргэлжлэх үү гэдгийг бас харах хэрэгтэй болж байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Бат-Эрдэнэ: Үйл ажиллагааны тайлантай танилцлаа. Компани урьд авсан том ажлуудаа дуусгаад, боломжийн ашигтай ажиллалаа. Тендерт оролцож, 2 ажил авсан, энэ онд хэрэгжүүлж дуусгана. Одоо мэргэжилтэй боловсон хүчин, ИТА нарынхаа асуудлыг анхаарах хэрэгтэй байна. Өвлийн улиралд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр цалин олгох хэрэгтэй гэж бодож байна. Мэргэжилтэй ажилтнууд маань Солонгос явж ажиллаж эхэллээ. Бетон эдлэлийн Баттогтох гэхэд л сарын цалингаа 2 өдөрт олж байна гэж ярьж байна. Залуу хүмүүст ийм цалингаар амьдрах боломжгүй шүү дээ.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: ТУЗ-ийн гишүүдийнхээ цалинг ч нэмэх шаардлагатай гэж бодож байна. Тахь Ко гэхэд 8,0 сая төгрөгийн цалин олгодог юм билээ.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Контор байрлаж байгаа энэ талбай дээр орон сууц барихаар 2017 онд ерөнхий төлөвлөгөөнд батлуулсан. Одоогоор хөрөнгө оруулалтын асуудлыг шийдээгүй байгаа.

Санхүүгийн бүртгэлээс харахад урьд онуудад 600-700 сая төгрөгийн цонх худалдаж авсан байдаг. Бид ярилцаад хуванцар цонхны үйлдвэр байгуулах төлөвлөгөө боловсруулаад ажиллаж байгаа. Тоног төхөөрөмжийн өртөг 100,0 сая төгрөг болно. Бетон эдлэлийн үйлдвэрийн конторын барилгыг засварлаад үйлдвэрээ байгуулна. Өвлийн улиралд, барилга угсралтын ажил зогссон үед цонхны үйлдвэрлэлээ явуулж, 10 хүн ч болсон тогтмол ажилтай болно.

Цаашид компанийн бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, цалин нэмэгдүүлэх, урамшуулал олгох, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хүний нөөцийг бүрдүүлэх бодлого барьж ажиллана. Компанийн удирдлагын зүгээс өөрсдийн үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, гадаад валют тодорхой түвшинд нөөцлөх, эргэлдүүлэх материалын нөөц бүрдүүлэх, банк санхүүгийн бүтээгдэхүүн ашиглах үүнд: Бонд, хувьцаа, хадгаламж, орон сууц барих, сантехникийн материалын

худалдаа эхлүүлэх, зарим нэг үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгө оруулалтын судалгаа хийж эрсдэлээс хамгаалах шаардлага үүсээд байна.

-Бетон эдлэл, Төмөр хийцийн үйлдвэрийг бие даалгах, өргөжүүлэх, материал үйлдвэрлэл дээр гүйцэтгэх удирдлага анхаарч ажиллах.

Мөн компанийн олон жилийн төсөл хөтөлбөрт оролцож байсан арвин их туршлага дээр тулгуурлан гадаад худалдаа эрхлэх боломжтой талаар судлаж байна.

Мөн Үндэсний статистикийн хорооноос гаргасан салбарын дундаж цалин, хүн амын дундаж цалингаас Хүрд ХК-ийн ИТА нарын цалин доогуур байгааг улсын жишигт хүргэн нэмэгдүүлэх зорилт тавьж байна. Энэ талаарх ажлыг эрчимжүүлж, Хүрд ОСК-ын ажилтнуудын дундаж цалинг 2023 оны 04-р улиралд салбарын жишиг цалинд хүргээд байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Одоо дараагийн асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд О.Шинэхүүгийн нэрийг дэвшүүлж байна. ТУЗ-ийн гишүүн Л.Оюунтогтох эрүүл мэндийн шалтгааны улмаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн. Октябрь овогтой Шинэхүү Бүлтэнхүү 2012 онд Монгол бизнес дээд сургуулийг Бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн. 2012 оноос Хүрд компанид нягтлан бодогч, ахлах нягтлан бодогчоор ажиллаж байгаа.

Хувьцаа эзэмшигчдийн санал шүүмжлэлийг сонссоны дараа компанийн 2023 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2024 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах, ТУЗ-ийн гишүүнийг сонгох санал хураалт явагдав.

Тооллогын комиссын дарга О.Шинэхүү санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар.

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **127,016.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %

2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **127,016.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %

3. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө батлах асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **127,016.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

4. 2024 оны удирдлагын зардлыг батлах асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны 127,016.0 ширхэг хувьцаа буюу 100,0 %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн сонгох асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны 127,016.0 ширхэг хувьцаа буюу 100,0 %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

ХУРЛЫН ШИЙДВЭР:


Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлав.
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгов.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 17.20 цагт хурал дуусав.

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Г.ГАНТУЯА